



ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ЕББДС-ИЙН 2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

**Лавлах зүйлс байвал доорх
хаягаар холбоо барина уу:**

Аймгийн Ернхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

[И-мэйл](#)

Аудитын багийн ахлагч

Аудитор Ц.Базарсад

Утас: 20272287

И-мэйл Bazaraatsend@yahoo.com

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4
• Гол шийдлүүд	6
• Залруулаагүй алдаа	6
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	7
• Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт.....	7
• Аудитын санал дүгнэлт	7

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

**Аймгийн Баянцогт сумын ЕББДС-ийн 2012 оны Санхүүгийн тайланд
ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Аймгийн Баянцогт сумын ЕББДС-ийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Баянцогт сумын ЕББДС-ийн төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баянцогт сумын ЕББДС тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирдлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

Ерөнхий менежерээс ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

1. Санхүүгийн ажилтнуудаас зөвхөн нягтлан бодогч санхүүгийн программ ашиглаж байна. Эд хариуцагч санхүүгийн программ ашиглахгүй байгаа ба няравын тайланг нягтлан бодогч өөрөө шивж оруулж байна.
2. Аймгийн МХГазрын төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт 2014 оны 1-р сард хийгдсэн тул хяналт шалгалт аудитыг санхүүгийн тайлан, журналд түшиглэн анхан шатны баримтыг үзээгүй болно.
3. Харилцахын баримтын бүрдэлийг шалгахад анхан шатны баримтын бүрдэлт сайн байна. Харилцахын баримтанд сар бүрийн мөнгөн гүйлгээний журналыг хэвлэж хавсаргадаггүй улирлаар хэвлэж хавсаргаж хяналтын түвшингийн хуулга, гүйлгээ хийсэн баримтуудыг үдсэн байна. Цаашид харилцахын орлого зарлагын журналыг хэвлэж баримтандаа хавсаргаж байх талаар ня-бо С.Цэцэгсүрэнгтэй ярилцсан
4. Тайлант онд түлш халаалтын зардлаас үндсэн хөрөнгөнд 308,0 мянган төгрөгийн мотор, эргэлтийн хөрөнгөнд 400,0 мянган төгрөгийн худгийн насос, мөн тээвэр шатахууны зардалд 388,7 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн

- дадлагын зардлаас 684,9 мянган төгрөгийн албан томилолт зардал гаргасан, 853,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн ч мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн зардлаар тусгагдаагүй гаргасан зардалдаа тайлагнасан байна. Цаашид Төсвийн тухай хуулийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг баримталж ажиллах
5. Зардлын бүлэг болон дангаар хянагдах зардлын бүлэглэлээс зардлыг санхүүжүүлэхдээ бичилтийн алдаа гаргасан байна. Үүнд: Түлш халаалтын зардлаас гэрэл цахилгааны зардалд 4834.0 мянган төгрөг, галч нарын нормын сүүний зардалд 64.4 мянган төгрөг, нормын бээлийн маск авахад 38.8 мянган төгрөг, мотор, хүрз, худгийн мотор 1248,0 мянган төгрөг, шатахууны зардалд 388,7 мянган төгрөгийн зардлыг гаргаж түлш халаалтын зардалд галч нарын нормын сүү, нормын бээлий маск, насосны үнэ болох 103,2 мянган төгрөгийг хааж бичсэн.
6. Сургуулийн хоол үдийн цайны зардал 29911,4 мянган төгрөг батлагдсанаас 27797,4 мянган төгрөг зарцуулж 2114,0 мянган төгрөгийн хэмнэлттэй гарсан байна. Хэмнэгдсэн зардлыг зардал хооронд шилжүүлэн зарцуулах зөвшөөрөл авч НДШимтгэлийн зардалд зарцуулсан байна. БСШУСайд, ССайдын 2009.12.14-ны 560/276 тоот тушаалаар батлагдсан Хүүхдийн цэцэрлэгийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол, МСҮТөвийн сургалцагчдын тэтгэлэгийн зардлын хэмнэлтийг тооцох, төвлөрүүлэх, зарцуулах журмын 2-ын 4-д Төв төрийн сан дахь Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хэмнэлтийн дансанд зардлын хэмнэлтийг төвлөрүүлнэ, 6-д Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нь тухайн улиралд гарсан зардлын хэмнэлтийг дараа улирлын эхний сарын 10-ны дотор , 4-р улирлын зардлын хэмнэлтийг 12 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэх дансанд шилжүүлж байна гэснийг тус тус зөрчсөн байна.
7. Нэг хүүхэд өдрийн хоолны зардлын норм 2350 төгрөг байхаас 2331 төгрөг, нэг хүүхэд өдрийн үдийн цайны зардлын норм 600 төгрөг байхаас 594 төгрөг зарцуулж батлагдсан төсөвт багтаан ажилласан байна.
8. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 2253,7 мянган төгрөгийн санхүүжилт орж 4412,4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын сангаас орсон хөдөлмөрийн чадвар түр алдалт болон жирэмсэн амаржсны тэтгэмжийн мөнгө байна. Авьяас хөтөлбөрт 2253,7 мянган төгрөг зарцуулсан байна.
- Ерөнхий Аудитор 2014.03.13-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.
- Эцэст нь аудитын явцад ерөнхий нягтлан бодогч С.Цэцэгсүрэн бидэнтэй хамтран ажилласан ажилчдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**Төв Аймгийн Аудитын Газар
2014.03.13**

Танилцуулга

1. Бид аймгийн Баянцогт сумын ЕББДС-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Баянцогт сумын ЕББДС-ийн ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баянцогт сумын ЕББДС тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Баянцогт сумын ЕББДС-ийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Баянцогт сумын ЕББДС-ийн захиралд тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Баянцогт сумын ЕББДС-ийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

- Байгууллагын дотоод хяналт ажилласан. Байгууллагын дотоод хяналтыг Сургуулийн захирлын тушаалаар дотоод хяналтын комисс байгуулагдаж төлөвлөгөөг батласан байна. Дотоод хяналтын талаар хийсэн ажлын тайланг илтгэх хуудсаар тайланг гаргаж баримтжуулсан байна.
- Дотуур байрны ариун цэвэр үзсэн
- Үдийн цай хөтөлбөрийн ирцийн бүртгэлд зарцуулалтанд 10 сард хяналт шалгалт хийсэн
- Хоолны орц норм зарцуулалтанд хяналт шалгалт хийсэн.
- Хүнсний материалын нийлэлтэнд дүн шинжилгээ хийсэн, няравын орлого, бэлтгэн нийлүүлэгчийн нийлүүлэлт 2 хяналт шалгалт хийсэн.

2. Орлогын талаар

- Батлагдсан төсвийн санхүүжилтыг 2012 оны гүйцэтгэлтэй харьцуулахад санхүүжилт 26826,6 мянган төгрөгөөр буюу өмнөх оноос 7,1 %-иар, үндсэн бус үйл ажиллагааны орлого өмнөх оныхтой ижил төлөвлөгдсөн байна. Үндсэн бус үйл ажиллагааны орлого нь дэлгүүрийн халаалтаас ордог байна.
- 2013 онд санхүүжилт 403321,4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 145.0 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр санхүүжилт 403321,4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 145.0 мянган төгрөгөөр бүрэн орсон байна.

3. Мөнгөн хөрөнгийн талаар

- Харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад Хадгаламж банкны түр данс үлдэгдэлгүй төрийн сангийн данс үлдэгдэлгүй байна.
- Мөнгөн хөрөнгийн гүйлгээ нь Сангийн сайдын 2010 оны 48 тоот тушаалаар батлагдсан “Бүлгийн дүнгээр хяналт тавих бараа үйлчилгээний зардлын бүлэглэл, эдийн засгийн ангилал тус бүрээр хяналт тавих зардлын зүйл” гэсэн журмыг мөрдөж зардал хооронд гүйлгэж зарцуулсан байна.

- Харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад төрийн сангийн данс 140815101 тоот дансаар санхүүжилт 403321,4 мянган төгрөг, өөрийн орлого 145.0 мянган төгрөг, зарлага 403466,4 мянган төгрөгийн зарцуулж 0 үлдэгдэлтэй хяналтын хуулгатай байна.
- 2013 оны 9 сард эрсдлийн аудит хийхэд анхан шатны баримтын бүрдэл сайн ур чадварын нэмэгдлийг сар улирал бүр шалгуур үзүүлэлтийн дагуу ажлыг нь дүгнэж байх зөвлөмж өгөгдснийг нягтлан бодогчид алдаагаа засаж ажилласан байна.
- Сургуулийн үдийн цай, хоолны зардлын 2114,0 мянган төгрөгийн хэмнэлтийг төвлөрүүлээгүй. Зардал хооронд шилжүүлэн зарцуулсан байна. БСШУСайд, ССайдын 2009.12.14-ны 560/276 тоот тушаалаар батлагдсан Хүүхдийн цэцэрлэгийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол, МСҮТөвийн сургалцагчдын тэтгэлэгийн зардлын хэмнэлтийг тооцох, төвлөрүүлэх, зарцуулах журмын 2-ын 4-д Төв төрийн сан дахь Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хэмнэлтийн дансанд зардлын хэмнэлтийг төвлөрүүлнэ, 6-д Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нь тухайн улиралд гарсан зардлын хэмнэлтийг дараа улирлын эхний сарын 10-ны дотор, 4-р улирлын зардлын хэмнэлтийг 12 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэх дансанд шилжүүлж байна гэснийг тус тус зөрчсөн байна.
- Нүүрсний нийлүүлэлтийг БҮБҮКА-тай төсвийн бүх байгууллагууд гэрээтэй нийлүүлдэн байна. Оны эхэнд нүүрсний үлдэгдэлгүй байсан ба тайлант онд 473,8 тн нүүрсийг нэг тн-ыг 80,0 мянган төгрөгөөр нийт 37903,8 мянган төгрөгөөр худалдан авч тайлант онд 466,3 тн буюу 37303,7 мянган төгрөгийн нүүрс зарцуулж үлдэгдэл 7,5 тн буюу 600,1 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэлтэй гарсан байна. Нүүрсний нэг аманд НРЈ-30-1ш, НРЈ-10-2ш 1,5-1,7 тонн хэрэглэдэг

4. Бараа материал

- Бараа материалын үлдэгдэл санхүүгийн тайлан дээрх үлдэгдэл няравын хүнсний материалын үлдэгдэлтэй зөрүүгүй тохирсон байна.
- Хүүхдийн хоолны зардлын гүйцэтгэлийг шалгахад жилийн дүнгээр нийт 8920 хүүхэд өдөрт 20797,4 мянган төгрөгний хоолны зардал гаргасан нь нэг хүүхэд өдөрт 2331 төгрөгний зардал гаргасан нь Засгийн газрын 2010 оны 342 дугаар тогтоолоор батлагдсан нэг хүүхэд өдөрт 2350 төгрөгний хоолны зардал гаргах нормоос 19 төгрөгөөр дутуу, жилийн нийт хүүхэд өдрөөр тооцоход 169,4 мянган төгрөгний хоол хүүхдүүдэд дутуу өгчээ. Хоолны зардалд 19580,6 мянган төгрөгний төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 18183,9 мянган төгрөгийн хоолны зардлыг гаргаж батлагдсан төсвийн дагуу зарцуулсан байна. Үдийн цай хөтөлбөрт жилийн дүнгээр 18177 хүүхэд өдөрт 10799,1 мянган төгрөгний зардал гаргаж нэг хүүхэд өдөрт 595 төгрөгний зардал гаргаж батлагдсан нормоос 5 төгрөгөөр дутуу бөгөөд жилийн дүнгээр 90,9 мянган төгрөгний үдийн цай дутуу өгсөн байна. Үдийн цай хөтөлбөрт 10330,8 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 9613,4 мянган төгрөг гаргаж батлагдсан төсвийн дагуу зарцуулсан байна.
- “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д “Эд хөрөнгийн тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хариуцна”, 11 дүгээр зүйлийн 2-ын 1-д “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийнэ” гэсэн заалтын дагуу ЕББДС-ийн захиралын тушаалаар комисс томилогдож тооллогыг хийсэн байна. Тооцоо бодсон актыг жилийн эцэст үйлдсэн, тооллогын комиссын хурлын протоколыг үйлдэж хавсаргасан байна.
- Бараа материалын үлдэгдэл санхүүгийн тайлан дээрх үлдэгдэл няравын хүнсний материалын үлдэгдэл 16661,7 мянган төгрөгөөр зөрүүгүй таарсан байсан.
- Эргэлтийн хөрөнгөнөөс 352,3 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХТ-ийн 2013.08.29-ны өдрийн 66 тоот тогтоолоор актласан байна.

5. Үндсэн хөрөнгө

- Хяналтын сорилоор “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д “Эд хөрөнгийн тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж,

байгууллагын удирдлага хариуцна”, 11 дүгээр зүйлийн 2-ын 1- д “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийнэ “ гэсэн заалтыг биелүүлж тооллого хийсэн байна.

- Улсын хөрөнгө оруулалтаар уурын зуух, спорт заалны их засварын ажил барилга байгууламж 69300,0 мянган төгрөг, яамны ХО-аар тоног төхөөрөмж 7355,1 мянган төгрөг, иргэдийн хандиваар тавилга эд хогшил 960,0 мянган төгрөг төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж 708,0 мянган төгрөг, ном 145,0 мянган төгрөг гэх мэт эх үүсвэрээр нийт 78468,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.
- ИТХТ-ийн 2013.08.29-ны өдрийн 66 тоот тогтоолоор 427,1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 122,6 мянган төгрөгийн тавилга эд хогшил акталж данснаас хассан байна.
- Элэгдлийг шалгахад элэгдэл зөв бодуулсан байна.

6. Авлага, өглөгийн талаар

- Тооцоо нийлсэн актыг гэрэл цахилгаан, татвар, нийгмийн даатгалтай тооцоо нийлсэн актаар үлдэгдлийг баталгаажуулсан байна.
- Авлага өглөгийн журналыг ерөнхий дэвтэрийн данстай тулган баталгаажуулсан
- Тооцоо нийлсэн актыг БҮБҮКА ХХК, НДХэлтэс, Холбоо, Эрчим хүч, Татварын хэлтэстэй тооцоо нийлсэн акттай байна. Бүгд өр авлагагүй байна.

7. Цалингийн талаар

- Цалингийн программаар цалинг бодож хэвшсэн байна.
- Ажилтнуудын цалинг ЗГ-аас гаргасан сүлжээнд нийцүүлэн үнэн зөв тогтоосон, бичигдсэн цалин НББ-ийн журнал, СХТ-ийн тоо дүнтэй тохирсон, цалингаас суутган тооцоо хийж байгаа тооцоолол үнэн зөв хийгдэж байна.
- 2013 онд 227 суралцагчидтай 43 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар батлагдсанаас 227 суралцагчидтай 43 орон тоотойгоор ажиллаж Ажилтнуудын цалинг ЗГ-аас гаргасан сүлжээнд нийцүүлэн үр дүнгээр нь тогтоосон байна.
- Цалингийн нэмэгдэл болон илүү цагийн олголтын байдлыг шалгахад сургалтын менежерийн цагийн тооцоо болон нэмэгдлийн тооцоог хийсэн байна.
- Цалинг санхүүгийн программаар хийж байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 7 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

6. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Байгууллагын зардлын гүйцэтгэлийг бодитой бус тайлагнах нь төсвийн төлөвлөгөөг хийх, хянах, батлах, шинжилгээ судалгааны дүнд нөлөөлөх тул зардлыг үнэн зөв тайлагнаж байх
- БСШУСайд, ССайдын 2009.12.14-ны 560/276 тоот тушаалаар батлагдсан Хүүхдийн цэцэрлэгийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол, МСҮТөвийн сургалцагчдын тэтгэлэгийн зардлын хэмнэлтийг тооцох, төвлөрүүлэх, зарцуулах журмын 2-ын 4-д Төв төрийн сан дахь Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хэмнэлтийн дансанд зардлын хэмнэлтийг төвлөрүүлнэ, 6-д Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нь тухайн улиралд гарсан зардлын хэмнэлтийг дараа улирлын эхний сарын 10-ны дотор , 4-р улирлын зардлын хэмнэлтийг 12 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэх дансанд шилжүүлж байна гэснийг мөрдөж ажиллах

7. Эдгээр асуудлуудыг ААГ болон Баянцогт сумын ЕББДС авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь

удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

8. Аудитын стандарт нь аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг.

Тайлбар мэдүүлгийн захидал

9. Аудитын үйл явцад аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд удирдлагаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт

1. ЕББДСургуулийн захирал нь аймгийн Боловсрол соёлын газар болон сургууль цэцэрлэгийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл, сумын Засаг дарга нараар үр дүнгээ дүгнүүлэлгүй үр дүнгийн мөнгөн урамшил авахгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлсэн
2. Эд хариуцагчын компьютерт санхүүгийн нэмэлт программ суулган нягтлан бодогчийн компьютертэй дотоод сүлжээгээр холбуулж, бүртгэл тайланг тусад нь хөтлүүлж байх зөвлөмж хэрэгжүүлээгүй учир нь үйл ажиллагааны төсөвт няравын програм суулгах хөрөнгө байхгүй байна.
3. Мэргэжлийн хяналтын санхүүгийн хяналтаар тогтоосон хувь хүмүүсээр татвар нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн төлбөрийн актыг төсвөөс төлсөн байгаа бөгөөд үүнийг төлөх хүмүүсээс авлагаар бүртгэж дансанд тусгах

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг ЕББДС-ийн захирал албан тоот ирүүлсэн бөгөөд дээрх зөвлөмжүүдээс 1-р зөвлөмжөөс бусдыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын санал дүгнэлт

10. Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

ААГ

2014.03.13